



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, "Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/24 дүгээр тушаал, Байгууллагын даргын 2016 оны А/255 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэн, харьяатын газрын даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Д.Түвшинтөр/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2016 оны А/207 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨРӨН

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2017 оны 148 дугаар
тушаалын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид "Байгууллага" гэх/-ын Даргын дэргэдэх зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

Хоёр. Зөвлөлийн хэлэлцэх асуудал

2.1. Зөвлөлийн хурлаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

2.1.1. тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан;

2.1.2. байгууллагын хагас, бүтэн жилийн тайлан, дүн шинжилгээний үнэлгээг баталгаажуулах;

2.1.3. ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

2.1.4. байгууллагын хэмжээнд хэрэгжих хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилт, явцын байдал;

2.1.5. албан хаагчийг томилох, чөлөөлөх, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулах;

2.1.6. шагнал урамшал, сахилгын шийтгэл;

2.1.7. үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшин, үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэх;

2.1.8. албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудал шийдвэрлэх, тусламж, тэтгэмж олгох;

2.1.9. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газар болон асуудал эрхэлсэн сайдаар шийдвэрлүүлэх, өргөн мэдүүлэх хууль тогтоомж, шийдвэрийн төсөл, танилцуулга;

2.1.10. нийтээр дагаж мөрдөх болон дотоод үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам, заавар, шийдвэр болон бусад баримт бичгийн төсөл;

2.1.11. бусад.

Гурав. Зөвлөлийн бүрэлдэхүүн

3.1.Зөвлөл дараахь бүрэлдэхүүнтэй байна.

- Зөвлөлийн дарга - Дарга;
- Нарийн бичиг -Тайлан төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн;
- Гишүүд:
- Дэд дарга;
 - Тамгын газрын дарга;
 - Хяналт шалгалтын газрын дарга;
 - Виз, зөвшөөрлийн газрын дарга;
 - Харьяатын газрын дарга;
 - Боомт, орон нутгийн хэлтсийн дарга;
 - Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга;
 - Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн дарга.

Дөрөв. Хурлын бэлтгэл хангах

4.1.Хэлэлцэх асуудлын жагсаалт, хурлын товыг Зөвлөлийн дарга батална. Зөвлөлийн даргын эзгүйд байгууллагын Дэд дарга орлоно.

4.2.Зөвлөлийн нарийн бичиг нь хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон холбогдох материалыг бэлтгэн, хурал болохоос ажлын хоёр өдрийн өмнө Зөвлөлийн гишүүдэд танилцуулж, саналыг авсан байна.

4.3.Зөвлөлийн гишүүдэд хурлын товыг мэдэгдэх, хэлэлцэх асуудлын материал бүрдүүлэх, танилцуулга хийх, тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг нарийн бичиг хариуцна.

4.4.Материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй асуудлыг Зөвлөлийн хуралд оруулахгүй.

4.5.Шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтныг оролцуулж өргөтгөсөн байдлаар хуралдаж болно.

Тав. Зөвлөлийн хурлын шийдвэр, түүний хэрэгжилт

5.1.Зөвлөл гуравны хоёроос доошгүй гишүүний ирцтэй хуралдаж, шийдвэр гаргана.

5.2.Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг нарийн бичиг бүртгэлжүүлэн холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, гүйцэтгэлд хяналт тавина.

5.3.Зөвлөлийн шийдвэрийн талаар холбогдох албан тушаалтанд танилцуулах, хамт олонд мэдээлэх асуудлыг Тамгын газар зохион байгуулна.

5.4.Нарийн бичиг хурлын тэмдэглэлийг бичгэн хэлбэрээр үйлдэж дарга, дэд даргад танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулна.

--- оОо ---